

БАТЛАВ: ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР

Б ДАШДАВАА

110/10 кВ-ын "Баруун" дэд станцын автомат удирдлагатай нум
унтраах реакторыг суурилуулахад олгох зураг
төсөл боловсруулах даалгавар

Дугаар...06/2020/01

2020. оны 06 сарын 19 өдөр.

Улаанбаатар хот

Байршил: Хан-Уул Дүүрэг Чингсийн өргөн чөлөө 45

Ерөнхий чиглэл: 110/10 кВ-ын "Баруун" дэд станцын нэг фазын газардлагын гүйдэл ба нуман газардлагын үед бий болох хэт хүчдэлийг бууруулах зорилгоор автомат удирдлагын систем бүхий реакторын байгууламжийг суурилуулах.

Техникийн үндсэн нөхцөл:

1. 110/10 кВ-ын "Баруун" дэд станцын нэг фазын газардлагын гүйдэл ба нуман газардлагын үед бий болох хэт хүчдэлийн тооцоог хийж тохирсон реакторыг тооцоогоор сонгох.
2. 10 кВ-ын гарсан шугамуудад шинээр тэг дарааллын гүйдлийн трансформатор суурилуулж, газардлагын хамгаалалтыг оруулах.
3. 110/10 кВ-ын "Баруун" дэд станцын 10 кВ-ын 1 ба 2-р секцэд суурилагдах автомат удирдлагын систем бүхий тохируулгатай реактор нь Олон улсын стандарт шаардлагыг хангасан байх.
4. Шинээр суурилуулж буй тоноглолууд нь өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ байх, $\pm 10\%$ -ийн хүчдлийн хэлбэлзэлд тэсвэртэй байх.
5. 110/10 кВ-ын "Баруун" дэд станцад суурилагдах тоноглол Монгол улсын цаг уурын нөхцлийг хангасан -45°C -ээс $+45^{\circ}\text{C}$, далайн түвшний өндөршил 1350 м-ээс дээш, IEC стандартыг хангасан байх

Угсралтын ажлын үед тавигдах шаардлага:

1. Дэд станцад 10 кВ-ын хуурай салгуур шинээр суурилуулж
2. Шинээр суурилагдах тоноглолууд нь дэд станцын аянга хамгаалалтын бүсэд багтах эсэхийг зураг төслийн шатанд тооцоогоор шийдвэрлэх.
3. Цахилгаан тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралт, туршилт, тохируулгын ажлыг "Техник ашиглалтын дүрэм", "Цахилгаан төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааны дүрэм" –ийн дагуу эрчим хүчний зураг төсөл, эрчим хүчний барилга угсралт хийх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх.

4. Шинээр суурилуулах реактор,фильтр, хуурай салгуур, удирдлагын систем ба резисторын холболт, газардуулах байгууламж, туслах тоноглолын зураг, техникийн өгөгдөл зэргийг албан тоотоор ЦДҮС ТӨХК-д ирүүлж танилцуулан зөвшөөрөл авсан байх.
5. Газардуулах байгууламжийг норм дүрмийн дагуу хийх ба ТАД-ийн 5.4.10 заалтын дагуу шинээр суурилуулах тоноглолын байнгын газардуулгыг дэд станцын газардуулгын системд холбох.
6. Угсралтын ажил дууссаны дараа техникийн акт, гүйцэтгэлийн зургийг ЦДҮС ТӨХК-д хүлээлгэн өгнө.
7. Тоноглолын ашиглалтын зааврыг Монгол хэл дээр боловсруулж хүлээлгэн өгөх.
8. Энэхүү зураг төсөл боловсруулах даалгавар олгогдсон өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчинтэй.

Хянасан:



Д.Чинбат / Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /



М.Өмербай / Шуурхай зохицуулалтын хэлтсийн дарга /



Н.Батбаяр / Реле хамгаалалт, туршилт хэмжүүрийн хэлтсийн дарга /

Боловсруулсан:  Ш. Мөнхжаргал / Зураг төслийн инженер /